



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1999 оны 3 дугаар
сарын 11 өдөр

Дугаар 4-39

Улаанбаатар
хот

**"Сансар кино театр" улсын үйлд-
вэрийн газрыг татан буулгах тухай**

1. Монгол улсын Иргэний хуулийн 31 дүгээр зүйл, "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 23 дугаар зүйл, "Сансар кино театр" улсын үйлдвэрийн газрын түрээсээр эзэмшиж байсан байр хувьчлагдсан зэргийг үндэслэн Нийслэлийн Баянзүрх дүүргийн "Сансар кинотеатр" улсын үйлдвэрийн газрыг 1999 оны 3 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн татан буулгасугай.


2. "Сансар кинотеатр" улсын үйлдвэрийн газрыг татан буулгах ажлыг зохион байгуулах комиссыг доорх бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга	Д.Галбадрах	—Нийслэлийн Өмчийн газрын Өмчийн хэлтсийн дарга
Гишүүдэд:	С.Жимээхүү	—Нийслэлийн Соёлын газрын мэргэжилтэн
	А.Элбэгсайхан	—Нийслэлийн Өмчийн газрын Өмчийн хэлтсийн мэргэжилтэн
	Т.Жанцанхорол	—Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн

3. Өмчийн газар (н.Буянмөнх)—т даалгах нь:

а/ "Сансар кинотеатр" улсын үйлдвэрийн газрын эд хөрөнгийг үнэлж, худалдах, өр төлбөрийг барагдуулсугай.

б/ "Сансар кинотеатр" улсын үйлдвэрийн газрыг татан буулгаж, өр төлбөрийг барагдуулсан тухай тайланг энэ оны 1 дүгээр улиралд багтаан танилцуулсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД